

Батлав.



"МЕРА"ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.Бүжин/



"МЕРА"ХХК

**МЕРА ХХК-ИЙН ТЭСРЭХ БОДИС ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН  
ЦОГЦОЛБОРТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын дугаар: МЕРА/2021.11.121

Тендерийн төрөл:Нээлттэй

Багц А: Таван Толгой салбарын тэсрэх материалын үйлдвэрийн цогцолбор


Багц Б: Гурван тэс сумд байрлах Жавлант ордын уурхайд байрлах тэсрэх материалын агуулах,  
ажилтнуудын кемп

Багц В: Налайх дүүрэгт байрлах тэсрэх материалын үйлдвэрийн цогцолбор

**Төслийн нэр, дугаар: Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ авах**

**Гэрээний нэр, дугаар: МЕРА/202111121**

**ХЯНАСАН:**

Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Огноо
Санхүү эрхэлсэн захирал	Б.Бямбасайхан		2021.11.12
Эрсдэл, комплаенс хариуцсан захирал	Д.Бадамчулуун		2021.11.12
ХААХ-ийн дарга	Г.Доржчулам		2021.11.12
ХАБЭАБОХ-ийн дарга	В.Ундрах-Эрдэм		2021.11.12

## Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ авах тендер

ЗАХИАЛАГЧ:	МЕРА ХХК
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨРӨЛ:	Мэргэжлийн ажил үйлчилгээ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:	МЕРА/202111121
УРИЛГЫН ДУГААР:	МЕРА/202111121
САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР:	Өөрийн хөрөнгө
ХАА-НЫ МӨРДӨХ ЖУРАМ:	Тусгайлсан тендер шалгаруулалтын нөхцөл
ЦАХИМ ТЕНДЕР ЭСЭХ:	Хялбаршуулсан цахим
ЗАРЛАГДСАН ОГНОО:	2021.12.01
ТЕНДЕРИЙН САНАЛ АВАХ ЭЦСИЙН ХУГАЦАА:	2021.12.14-ний 10:00 цагт

### НЭГ.ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

“МЕРА” ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх” тухай МЕРА/202111121 дугаартай тендер шалгаруулалтад баримт бичиг ирүүлэхийг урьж байна.

Үнийн болон ажил үйлчилгээ үзүүлэх санал ирүүлэх ажлын даалгавар, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн санал болон бусад холбогдох бичиг баримтыг **2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 10 цаг 00 минут**-аас өмнө “МЕРА” ХХК-ийн [TENDER@MERA.MN](mailto:TENDER@MERA.MN) цахим хаягаар ирүүлнэ.

“МЕРА”ХХК-ийн төв оффисын байр: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Жанжин Д.Сүхбаатарын талбай 8/1, Сити тауэр, 17 давхар.

**Утас: 75556677, 94677695 Худалдан авалтын мэргэжилтэн Б.Удвал**

## ХОЁР. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

### А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Тендерийн цар хүрээ</b>                 | <p>1.1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэнд (цаашид ТШӨХ гэх) дурдагдсан <b>Захиалагч</b> нь Гэрээний хавсралт А-д тодорхойлсон <b>үйлчилгээг</b> үзүүлэх этгээдийг сонгохоор тендер шалгаруулж байна. <b>ТШӨХ-д</b> гэрээний нэр болон дугаарыг заасан болно.</p> <p>1.2. Шалгарсан тендерт оролцогч нь <b>ТШӨХ-д</b> заасан хугацаанд үйлчилгээг гүйцэтгэж дуусгах үүрэг хүлээнэ.</p> <p>1.3. Тендерт оролцогч нь аль ч багцад оролцож болно.</p>  |
| <b>2. Санхүүжилтийн эх үүсвэр</b>             | <p>2.1. Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрээр өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.</p>   |
| <b>3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл</b> | <p>3.1. Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагч болон тендерт оролцогч, гүйцэтгэгч буюу гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцож, гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой ба “Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдэгдэл”-ийг тодорхойлсон албан бичиг ирүүлнэ.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.</p>   |
| <b>4. Эрх бүхий тендерт оролцогч</b>          | <p>4.1. Тендерт оролцогч нь Монгол Улсын Иргэний эрх зүйн харилцаа, хууль тогтоомжийн 22-р бүлэг, Монгол улсын Иргэний хуулийн 27-р бүлэгт заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p>  |
| <b>5. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>     | <p>5.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p>  |
| <b>6. Тендерийн иж бүрдэл</b>                 | <p>6.1. Тендер оролцогчийн чадвар Тендерт оролцогч нь Бүлэг III–т заасан Тендерийн маягт болон чадварын мэдээллийн маягтыг бөглөж, хийх ажлын аргачлалын талаарх урьдчилсан тайлбар, ажлын хуваарь, шаардлагатай бол холбогдох график зургийн хамтаар ирүүлнэ.</p> <p>6.2. <b>ТШӨХ-д</b> өөрөөр заагаагүй бол тендерт оролцогч дараах мэдээлэл болон баримт бичгийг тендерийн хамт Бүлэг III-т заасан маягтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>(а) Хууль эрх зүйн статус, бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны чиглэл, буюу үүсгэн байгуулагдсаныг тодорхойлох албан ёсны баримт бичгийн эхээс хийсэн хуулбар, тендерт оролцогчийн өмнө үүрэг хүлээж түүнийг төлөөлж тендерт гарын үсэг зурах этгээдийн албан ёсны итгэмжлэл.</li><li>(б) <b>ТШӨХ-д</b> тодорхойлсон хугацаанд сүүлийн Сүүлийн 2 жилийн санхүүгийн баталгаажсан тайлангийн хуулбар жил бүрээр гаргаж ирүүлэх.</li><li>(в) <b>ТШӨХ-д</b> тодорхойлсон хугацаанд тухайн үйлчилгээтэй шинж чанар болон хэмжээгээрээ ижил төстэй үйлчилгээг гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэсэн болон одоо хийж байгаа тухайг захиалагч болон түүнтэй холбоо барьж болох нэр, хаяг, төрөл хэмжээ зэрэг гэрээний дэлгэрэнгүй мэдээллийн хамт жил тус бүрээр гаргаж ирүүлэх.</li><li>(г) Тухайн гэрээг хийж гүйцэтгэхэд шаардлагатай гол тоног төхөөрөмжүүдийн жагсаалтыг гаргаж ирүүлэх</li></ul> |

- (д) Гэрээг хэрэгжүүлэхэд санал болгож буй удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл
- (е) Захиалагч тухайн тендерт оролцогчийн харилцагч банкнаас түүний талаар тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл
- (ж) ТШӨХ-д тодорхойлсон жилд тухайн тендерт оролцогчтой холбоотой гарсан аливаа зарга маргааны тапаарх мэдээлэл, маргааны тоо
- 6.3. Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх олж авахын тулд дор дурдсан чадварын доод шалгуурыг хангасан байна:
- (а) Жилийн турш гүйцэтгэсэн Үйлчилгээний тоо хэмжээ нь **ТШӨХ-д** заасан дүнгээс багагүй байх;
- (б) **ТШӨХ-д** тодорхойлсон хугацаанд тухайн гэрээтэй төрөл, нарийн төвөгтэй байдлаараа дүйцэхүйц ижил 2-оос доошгүй үйлчилгээ үзүүлэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх (дурдсан ажлын доод тал нь 70 хувь нь хэрэгжсэн байх нөхцөлд энэ шаардлагыг хангасан гэж үзнэ).
- (в) **ТШӨХ-д** жагсаалтаар заасан зайлшгүй байх үндсэн тоног төхөөрөмжүүдийг цаг хугацаанд нь бэлэн байлгах тухай санал (өөрийн эзэмшлийн, түрээслэх, хөлслөх, г.м);
- (г) Гэрээнд заасан үйлчилгээтэй төрөл, дүнгээрээ дүйцэхүйц үйлчилгээний 3-аас доошгүй жил, түүний дотор 2-оос доошгүй жилд нь гэрээг хариуцаж ажилласан туршлага бүхий менежертэй байх.
7. **Тендер шалгаруулалтад оролцох зардал**
- 7.1 Тендерт оролцогч тендерийг бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.
8. **Тогтмол үнэ**
- 8.1 Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
9. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
- 9.1 Нийлүүлэх бараа, ажил үйлчилгээ нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа, ажил үйлчилгээ нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
- 9.2 Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
10. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 10.1 Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна
11. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 11.1 Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 11.2 Санал болгох ажил үйлчилгээ нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөлд сонголтоор үнийн санал ирүүлнэ.
- 11.3 Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон эсвэл тусгай шаардлага хангасан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

12. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл

12.1 Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

13. Тендерийн  
баримт  
бичгийн  
агуулга

13.1 Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТООЗ-ны 12 дугаар зүйлийн дагуу оруулсан нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ:

Бүлэг

1. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
3. Тендерийн маягт болон чадварын мэдээллийн маягт
4. Гэрээний ерөнхий нөхцөл

13.2 Тендерт оролцогч нь тендерийн баримт бичиг дахь бүх зааварчилгаа, маягтууд, нөхцөлүүд болон тодорхойлолтуудыг шалгаж нягтласан байвал зохино. Тендерийн баримт бичигт ирүүлэхийг шаардсан бүх мэдээллийг дутуу ирүүлэх, эсхүл тендерийн баримт бичгийг томоохон зөрүүгүй хангаж чадаагүй тендер ирүүлэх нь тендерт оролцогчийн эрсдэлд хамаарах ба энэ нь түүний тендерээс татгалзах үндэслэл болж болно.

14. Тендерийн  
баримт  
бичгийг  
тодруулах

14.1 Тендерт оролцохыг сонирхогч аливаа этгээд нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ [procurement@mera.mn](mailto:procurement@mera.mn) цахим шуудан эсхүл утсан холбоо ("утсан холбоо"-нд зөвхөн факсыг хамруулна)-гоор ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар ирүүлнэ.

Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчдод бичгээр, цахим шуудан /и-мэйл/ эсхүл утсан холбоогоор мэдэгдэнэ.

15. Тендерийн  
баримт бичигт  
нэмэлт  
өөрчлөлт  
оруулах

15.1 Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлт оруулах хүсэлтээ [procurement@mera.mn](mailto:procurement@mera.mn) цахим хаягаар өгнө.

15.2 Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр цахим шуудан, утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид цахим шуудангаар /и-мэйл/ мэдэгдэх үүрэгтэй.

15.3 Шаардлагатай бол тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийг тендер бэлтгэхдээ авч үзэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчдод олгох үүднээс захиалагч ТООЗ-ны 26.1-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

## В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

<b>16 Тендерийн хэл</b>	<p>16.1 Тендер, түүнчлэн тендертэй холбоотой асуудлаар захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидалууд болон бусад баримт материалуудыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. Тендерийн барим бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвөл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.</p> <p>16.2 Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТШӨХ-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг үндэслэн тендерийн үнэлгээнд харгалзах болно.</p>
<b>17 Тендерийн иж бүрдэл</b>	<p>17.1 Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>(а) Тендерийн маягт (Бүлэг III-т заасан маягтын дагуу)</li> <li>(б) Үнэлэгдсэн үйл ажиллагааны хуваарь;</li> <li>(в) Чадварын мэдээлэл болон бусад ТШӨХ-д тодорхойлсон баримт бичиг.</li> </ul> <p>17.2 “Тендерийн урилга”-д заасан бол тендерт оролцогч нь нэг буюу нэгээс олон багцад оролцохоор тендер ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд нэгээс илүү багцад гэрээ байгуулах эрх авах бол аливаа үнийн хөнгөлөлт үзүүлэх тухай саналаа хамт ирүүлж болно.</p>
<b>18 Тендерийн маягт болон үе шатны ажлын хуваарь</b>	<p>18.1 Тендерт оролцогч нь 3 дугаар бүлэг буюу тендерийн жишиг маягтуудаас зохих маягтыг ашиглан тендерийн санал ба үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарийг бэлтгэж ирүүлнэ. Эдгээр маягтын үг, өгүүлбэрт утга агуулгыг нь өөрчилсөн буюу орхигдуулсан аливаа өөрчлөлт хийхийг зөвшөөрөхгүй. Маягт дахь бүх хоосон зайд шаардсан мэдээллийг нөхөж бичнэ.</p>
<b>19 Хувилбарт тендер</b>	<p>19.1 ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.</p>
<b>20 Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт</b>	<p>20.1 Тендерийн маягт болон үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарьт тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон үнийн хөнгөлөлт нь дараах шаардлагад нийцсэн байна.</p> <p>20.2 Тендерийн үнэ нь ТООЗ-ны 1.1-д тодорхойлсон гэрээт ажлын нийт өртөгийг хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарь<sup>1</sup> үндэслэнэ.</p> <p>20.3 Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн<sup>2</sup> бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ өгнө. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.</p> <p>20.4 Тендерийн маягтад тусгасан үнэ нь санал болгож буй аливаа үнийн хөнгөлөлт тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.</p>

- 20.5 Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусгасан байна.
- 20.6 Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.
- 20.7 Тухайн тендерийн дагуу гүйцэтгэх ажлыг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТООЗ-1.3 дахь хэсгээс лавлана уу. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.
- 20.8 ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТООЗ-ны 30 дугаар зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч үнэ тохируулахаар заасан тохиолдолд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.
- 21 Тендерийн болон төлбөрийн валют** 21.1 Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дах хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.
- 22 Техникийн саналийн бүрдэл баримт бичиг** 22.1 Тендерт оролцогч нь ажлын гүйцэтгэл болон хугацааны талаар захиалагчийн шаардлагад нийцэж буйг нарийвчлан харуулсан график, ажлыг гүйцэтгэх арга барил, тоног төхөөрөмж, ажиллах хүчин, ажлын хуваарийн талаарх мэдэгдэл зэргийг агуулсан Техникийн саналыг тендерийн баримт бичгийн 3 дугаар бүлэгт заасан маягтаар бусад мэдээллийн хамтаар бэлтгэж тендерт ирүүлнэ.
- 23 Тендер хүчинтэй байх хугацаа** 23.1 Тендер нь захиалагч ТООЗ-ны 26.1-т заасны дагуу тогтоосон тендер нээх он, сар, өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендерт оролцогчоос тендерийн маягтад санал болгож ирүүлсэн тендер хүчинтэй байх хугацаа нь захиалагчийн тогтоосон дээрх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүний тендерийг үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж, уг тендерээс татгалзана.
- 23.2 Онцгой нөхцөл байдал үүсч тендер хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд захиалагч бүх тендерт оролцогчид хандаж өөрсдийн тендер хүчинтэй байх хугацааг сунгах тухай мэдэгдэл цахим шуудангаар /и-мэйл/ эсвэл цахим шуудангаар мэдэгдэнэ.
- 24 Тендерийн баталгаа** 24.1 Тендерт оролцогчидоос тендерийн баталгаа шаардахгүй.
- 24.2 Сүүлийн хоёр жилийн санхүүгийн баталгаажсан тайлангийн хуулбар ТООЗ-ын 6.2 (б) дагуу шаардана.
- 25 Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах** 25.1 Тендерт оролцогч 15 дугаар зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавсарган **НЭГ PDF** файл болгон [tender@mera.mn](mailto:tender@mera.mn) цахим хаяг илгээнэ.

- 25.2 Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.
- 25.3 Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.

## Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

- |   |  |
|---|--|
| <b>26 Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх</b>                 | <p>26.1 Тендерт оролцогчид өөрийн тендерийг <a href="mailto:tender@mera.mn">tender@mera.mn</a> цахим шуудангаар /и-мэйл/ <b>НЭГ PDF</b> файл болгон хүргүүлнэ. Хэрэв нэг PDF болгоогүй тохиолдолд бичиг баримтын бүрдэл хангаагүй шалтгаанаар тус тендерийн баримт бичгээс татгалзана.</p> <p>26.2 Ирүүлэх материалд дараах зүйлс багтана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>(а) тендерт оролцогчийн нэр, хаягтай байх;</li> <li>(б) ТШӨХ-д заасан хаягаар ТООЗ-ны 1.1-д заасан захиалагчийн нэр дээр хаяглах;</li> <li>(в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТООЗ-ны 1.1 болон <b>ТШӨХ-д</b> тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаар тодорхой бичсэн байх;</li> <li>(г) ТООЗ-ны 27.1-т заасан хугацаанаас өмнө "НЭЭЖ ҮЛ БОЛНО" гэж тэмдэглэгдсэн байх.</li> </ul>         |
| <b>27 Тендер хүлээн авах эцсийн хугацаа</b>                   | <p>27.1 Захиалагч тендерийг ТШӨХ-д заасан хаягаар, нээх огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>27.2 Захиалагч ТООЗ-ны дагуу тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.</p>  |
| <b>28 Хугацаа хоцорсон тендер</b>                             | <p>28.1 Захиалагч ТООЗ-д заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг "хугацаа хоцорсон" гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.</p>   |
| <b>29 Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах</b> | <p>29.1 Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.</p> <p>29.2 Тендерт нэмэлт, өөрчлөлт оруулах, солих эсхүл тендерийг буцааж авах мэдэгдлийг <a href="mailto:procurement@mera.mn">procurement@mera.mn</a> хаягт и-мэйлээр ирүүлэх ба и-мэйлийн утга дээр "НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ТУХАЙ", "ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ", эсхүл "ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ" гэсэн нэмэлт бичиглэл хийж ТООЗ-ны 24 дүгээр зүйлд заасны дагуу захиалагчид ирүүлнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.</p> |



29.3 Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш тендерт аливаа нэмэлт өөрчлөлт хийхийг хориглоно.

#### **Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ**

- |                                 |   |
|---------------------------------|---|
| <b>30 Тендерийг нээх</b>        | <p>30.1 Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт онлайнгаар зохион байгуулна.</p> <p>30.2 Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, хэрэв захиалагч шаардсан бол тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.</p> <p>30.3 Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна.</p> <ul style="list-style-type: none"><li>(а) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ солисон эсэх;</li><li>(б) тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт (зөвшөөрсөн бол хувилбарт тендерийн үнэ), шаардлагатай бол эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;</li><li>(в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.</li></ul> <p>30.4 Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хоцорч ирүүлснээс бусад тендерээс тендерийн нээлтийн үед татгалзахыг хориглоно.</p> |
| <b>31 Нууцлал</b>               | <p>31.1 Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.</p> <p>31.2 Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болж болно.</p> <p>31.3 Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоо зөвхөн бичгээр харилцана.</p>   |
| <b>32 Тендерийг тодруулах</b>   | <p>32.1 Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний ирүүлсэн тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тодруулга авахдаа зөвхөн албан бичгээр харилцана. Гэхдээ ТӨӨЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.</p>  |
| <b>33 Тендерийг хянан үзэх,</b> | <p>33.1 Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө дараах шаардлагыг хангаж буй эсэхийг нягтлана. Үүнд:</p>   |

**шаардлагад  
нийцсэн  
эсэхийг  
тогтоох**

- (а) ТООЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;
- (б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж баталгаажуулсан эсэх;
- (в) шаардагдах баталгааг зөвшөөрөгдсөн маягтаар ирүүлсэн эсэх;
- (г) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх,
- (д) ажил гүйцэтгэхэд тавигдах бусад шаардлагыг хангасан эсэх.

33.2 Шаардлагад нийцсэн тендер нь тендерийн баримт бичигт тавигдсан нөхцөл шаардлага, ялангуяа тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн болон гэрээ хэрэгжүүлэх чадвар, техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээг материаллаг зөрүүгүйгээр хангасан тендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ:

- (а) техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
- (б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
- (в) тендерийн баримт бичигт шаардсанаас зөрүүтэйгээр санал болгосон тендерийн саналыг хүлээн зөвшөөрөх, түүнийг засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.

33.3 Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

**34 Алдааг  
залруулах**

34.1 Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

34.2 Захиалагч хамгийн сайн үнэлэгдсэн тендерийн үнэд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр эсвэл цахим шуудангаар /и-мэйл/ баталгаажуулж авна.

**35 Нэг валютад  
хөрвүүлэх**

35.1 Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэнэ.

**36 Дотоодын  
давуу эрх**

36.1 Захиалагч ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт давуу эрхийн зөрүү тооцохгүй.

**37 Тендерийг  
үнэлэх,  
харьцуулах**

- 37.1 Захиалагч зөвхөн ТӨӨЗ-ны дагуу хянан үзээд шаардлагад нийцсэн гэж тогтоосон тендерүүдийг үнэлж, харьцуулна.
- 37.2 Захиалагч тендерийг үнэлэхдээ ТӨӨЗ-ны 28 дугаар зүйлийн дагуу зарлагдсан тендерийн үнэд дараах байдлаар залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Үүнд:
- (а) ТӨӨЗ-ны 33.1 –дзаасны дагуу алдааг залруулах;
  - (б) үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь дахь магадлашгүй ажлын зардлын дүнг хасах. Харин захиалагчийн шаардсаны дагуу тендерт оролцогчийн санал болгосон ажил-өдрийн зардлыг хасахгүй;
  - (в) ТӨӨЗ-ны 29.4-д заасны дагуу зарлагдсан тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тооцож, тусгах;
  - (г) Захиалагч материаллаг бус зөрүүтэй буюу бага хэмжээний зөрүүтэй гэж үзсэн тохиолдолд орхигдуулсан зүйлийн тоо хэмжээний дутагдал, эсвэл илүүдлийн зөрүүг мөнгөөр илэрхийлэн тооцоолж, тендерийн үнэд тусгах;
- 37.3 Захиалагч нь аливаа өөрчлөлт, зөрүү болон хувилбарт тендерийг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах эрхтэй. Тендерийн баримт бичгийн шаардлагыг давуулж биелүүлэх, эсхүл бусад замаар тендерийн баримт бичгийн шаардлагад заагаагүй ашиг тусыг захиалагчид санал болгосон өөрчлөлт, зөрүү, хувилбарт тендер болон бусад хүчин зүйлийг захиалагч тендерийг үнэлэхэд харгалзахгүй.
- 37.4 ТШӨХ-д тусгайлан заагаагүй бол захиалагч үнэлгээнд дараах хүчин зүйлсийг харгалзахгүй:
- (а) *Гэрээний болон арилжааны зөрүү:*  
Гэрээний болон худалдааны нөхцөлөөс зөрүүтэйгээр санал болгосон болон орхигдуулсан зүйл бүрийн өртгийг тооцоолж үнэлгээнд харгалзана.
  - (б) *Ажлын гүйцэтгэлийн хугацаа:*  
Энэ тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэх ажлыг техникийн тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэлийн хуваарийн дагуу болон түүнд багтааж дуусгах шаардлагатай тендерт оролцогчийн үнэ тус хуваарьт үндэслэсэн байх шаардлагатай. Тус хуваарьт зааснаас өмнө дуусгавар болгохыг санал болгосон тендерт урамшуулал олгохгүй. Тус хуваарьт зааснаас хоцорч ажлыг гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд тендерийн үнийн ТШӨХ-д заасан хувийг<sup>3</sup> тендерийн үнэ дээр нэмнэ. Ажлын гүйцэтгэлийн хуваарьт зааснаас ТШӨХ-д зааснаас<sup>4</sup> илүү сар хоцроож дуусгахыг санал болгосон тендерээс татгалзана.
  - (в) *Төлбөрийн хуваарийн зөрүү:*  
Гэрээний тусгай нөхцөлд дурдсан төлбөрийн хуваариас өөр хуваарь санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор төлбөрийн хуваарьт зааснаас өмнө

төлөгдөх дүнд сарын ТШӨХ-д заасан хувь<sup>5</sup>-тай тэнцэх хүү тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

- 37.5 Хэрэв тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэх ажил нь ТООЗ-ын 1.3-ийн дагуу хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг дараах байдлаар хийнэ. Үүнд:
- (а) багц тус бүрт ТООЗ-ны 32.1-32.3-т заасны дагуу тендерийн үнэлгээг хийж, харьцуулах хамгийн бага үнэтэй тендерийг тодорхойлох;
  - (б) хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд нөхцөлт үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерт уг нөхцөлт үнийн хөнгөлөлтийг тооцох;
  - (в) дээрх үнэлгээг хийсний дараа захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсвэл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, тэдгээрээс хамгийн үр ашигтай хувилбарыг сонгох;
  - (г) нэг тендерт оролцогчид хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх олгох тохиолдолд тухайн этгээд гэрээг хэрэгжүүлэх чадварын шаардлагыг хангаж буй эсэхийг дахин магадлах. Хэрэв чадварын шаардлага хангахгүй бол тухайн этгээдэд гэрээ хэрэгжүүлэх чадварт нь тохирох багцад гэрээ байгуулах эрх олгож болно.
- 37.6 Шаардлагад нийцсэн тендерүүдийг ТООЗ-ны 36.2, 36.3 болон 36.5-д заасны дагуу үнэлж, харьцуулах үнийг тогтоосний үндсэн дээр хамгийн бага харьцуулах үнэтэй эсвэл техникийн шаардлага хангасан тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна.
- 38 Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**
- 38.1 Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.
- 38.2 Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 6.2-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 31 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТООЗ-ны 6.3-т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч ТООЗ-ны 19.4 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.
- 38.3 “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.
- 39 Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах**
- 39.1 Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

## **Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ**

- 40 Гэрээ байгуулах эрх олгох шалгуур**
- 40.1 Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.
- 41 Гэрээ байгуулах эрх**
- 41.1 Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдлийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө шалгарсан тендерт оролцогч

<b>олгох тухай мэдэгдэл</b>	болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг и-мэйл хаягаар хүргүүлнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
	41.2 Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг мэдэгдсэнээс хойш ажлын 10 хоногийн дотор гэрээг баталгаажуулж гарын үсэг зурна.
	41.3 Гэрээ байгуулсан тухай мэдээлсний дараагаар, шалгараагүй тендерт оролцогч тендерийг нь татгалзсан үндэслэл, шалтгааны талаар тайлбар ирүүлэх хүсэлтийг бичгээр гаргаж болно. Ийм хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.
<b>42 Гэрээнд гарын үсэг зурах</b>	42.1 Захиалагч нь гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлүүдийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.
	42.2 Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 6-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хоногийн дотор түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.
	42.3 Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн даруй гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.
<b>43 Гүйцэтгэлийн баталгаа</b>	42.1 Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас гэрээний тусгай нөхцөлд заасан дүнгээр, ТШӨХ-д заасан маягтаар болон гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид ирүүлнэ.
	42.2 Гүйцэтгэлийн баталгааг: (а) тендерт оролцогчийн сонголтоор Монгол улсад байрладаг банкаар буюу гадаадын банкны Монгол улсад байрладаг харилцагч банкаар, эсхүл (б) захиалагчийн хүлээн зөвшөөрсөн гадаадын банкаар гаргуулна.
	42.3 Шалгарсан тендерт оролцогч ТӨӨЗ-ны 41.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох, тендерийн баталгааг гүйцэтгүүлэх хангалттай үндэслэл болно.
<b>44 Урьдчилгаа төлбөрийн баталгаа</b>	44.1 Захиалагч <b>ТШӨХ-д</b> заасан хэмжээнээс хэтрэхгүй урьдчилгаа төлбөрийг гэрээний нөхцөлд заасны дагуу гаргаж өгнө.

ГУРАВ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Хүснэгт№1

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
(1.1)	Захиалагч нь: “МЕРА” ХХК Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Жанжин Д.Сүхбаатарын талбай 8/1, Сити тауэр, 23 давхар. Гэрээний нэр болон дугаар нь: МЕРА ХХК-д Харуул, хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгох сонгон шалгаруулалт МЕРА/202111121
(1.2)	Гэрээт ажлын хугацаа 2022.01.01-2022.12.31-ний хугацаанд үргэлжилэх ба эхний 6 сарын гүйцэтгэлийг үнэлж гэрээг цаашид үргэлжлүүлэх эсэхийг шийднэ.
(2.1)	Санхүүжилтийн эх үүсвэр: Өөрийн хөрөнгө Төсөвт өртөг: Багц-А 296,400,000 төгрөг /НӨАТ-тай/ Багц-Б 50,400,000 төгрөг /НӨАТ-тай/ Багц-В 143,520,000 төгрөг /НӨАТ-тай/
(3.1)	“Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдэгдэл”-ийг тодорхойлсон албан бичиг (Очир Ундраа групп болон МЕРА ХХК-ийн хэмжээнд)
(6.2.а)	<ul style="list-style-type: none"> <li>• Компанийн танилцуулга.</li> <li>• Аж ахуйн нэгжийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.</li> <li>• Удирдах албан тушаалтнуудын танилцуулга, товч намтар (компанийн гүйцэтгэх захирал, сургалт хариуцсан албан тушаалтан, ХАБЭА хариуцсан ажилтан, ээлжийн ахлах г.м);</li> <li>• Ажилтнууд нь үндсэн ажилтан байх ба түүнийг баталгаажуулах танилцуулга, тэдгээрийн сүүлийн 2 жилийн НД-ын шимтгэл төлөлтийг баримтжуулсан материал (НД-ын дэвтрийн хуулбар байж болно);</li> <li>• Сүүлийн 2 жилд харуул хамгаалалтын ажилтнуудын хамрагдсан сургалтын үнэмлэхийн (үүнд галт зэвсэгтэй харьцах эрхийн сургалт мөн хамаарна) хуулбарууд, дотоод сургалтын бүртгэлүүд;</li> <li>• Галт зэвсэг эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа /E-mongolia-аас авч болно./</li> <li>• Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт. /E-mongolia-аас авч болно./</li> <li>• Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт. /E-mongolia-аас авч болно./</li> <li>• Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт /E-mongolia-аас авч болно./</li> <li>• Компанийн үйл ажиллагаатай холбоотой дотоод бодлого, журам, стандартууд;</li> <li>• Хүний нөөц, цалин урамшууллын талаар баримталдаг бодлого;</li> <li>• Үнийн саналд ирүүлсэн мөнгөн дүнгийн дэлгэрэнгүй задаргаа;</li> </ul>
(6.2 б)	<ul style="list-style-type: none"> <li>• Сүүлийн 2 жилийн санхүүгийн баталгаажсан тайлангийн хуулбар;</li> </ul>

(6.2 в)	<ul style="list-style-type: none"> <li>• Тендерт оролцогч нь 3-аас дээш жилийн туршлагатай байх бөгөөд сүүлийн 3 жилд ажилласан төслүүдийн харилцагч байгууллагаас гаргасан тодорхойлолт, албан бичиг болон гэрээ дүгнэсэн актын хуулбарын аль нэгийг илгээх ба жил тус бүр 2-оос доошгүй гэрээ дүгнэсэн акт, тодорхойлолт ирүүлнэ.</li> </ul>
(6.2 г)	<ul style="list-style-type: none"> <li>• Галт зэвсгийн гэрчилгээний хуулбарууд;</li> <li>• Радио давтамж ашиглах эрхийн бичгийн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлэх,</li> <li>• Харуул хамгаалалтын ажилтны дүрэмт хувцас, таних тэмдэг, тусгай хэрэгсэл (радио станц, гав, резинэн ба цахилгаан бороохой, нулимс асгаруулагч газ, резинэн ба хуванцар сумтай буу, духны болон гар чийдэн, согтуурлын зэрэг тогтоогч, тандагч багаж, тоон үзүүлэлттэй</li> </ul>
(6.2 д) болон 19.1	<p><b>Багц №А Тавантолгой салбар:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <u>Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын бүс</u> - Хашаалсан талбайн хэмжээ 8га.</li> <li>- <u>Автомашинны гараж, дотооддоо ашигладаг ШТС</u> - Хашаалсан талбайн хэмжээ 1га.</li> <li>- <u>Кемп</u> - Хашаалсан талбайн хэмжээ 1,5га. Дээрх объектууд нь хоорондоо ойрхон буюу 750м орчим радиуст багтдаг тул өдөр тутмын харуул хамгаалалтын ажил үйлчилгээнд автомашин ашиглахгүй байж болно.</li> </ul> <p><b>Дээрх бүх объектуудад нэг ээлжэнд 12 хамгаалалтын ажилтан, 1 ээлжийн ахлах нийт 13 харуул хамгаалалтын ажилтан, 1-ээс доошгүй галт зэвсэгтэй байх ба 6 постонд өдөр, шөнийн ээлжээр гарна. Ростор 15/15 хоногийн хугацаатай. Ажилтнуудын ростер солих унааны зардлыг Гүйцэтгэгч тал хариуцна. Тус салбарт байрлах монгол гэр, ажилтнуудын хоол, өвлийн түлшийг МЕРА ХХК хариуцна.</b></p> <p><b>Багц №Б Гурвантэс салбар:</b></p> <p><u>Гурвантэс сумын Жавхлант ордын уурхайн тэсрэх бодисын агуулах</u> – уурхайд байрлах тэсрэх материалын агуулахын пост. Тус постод нэг ээлжэнд 2 хамгаалалтын ажилтан (галт зэвсэгтэй) өдөр шөнийн хуваариар ажиллана. Росторын хугацаа 15/15 хоног. Харуул хамгаалалтын ажилтнуудын хоол, үйлчилгээг өөрсдөө гүйцэтгэх. Тус салбарт байрлах монгол гэр, өвлийн түлшийг “МЕРА” ХХК хариуцна.</p> <p><u>Жавхлант Орд Уурхайн ажилтнуудын кэмп</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Уурхайд байрлах тус кэмп нь нийт 200x150м<sup>2</sup> талбайд байрлах бөгөөд 48гэр, 12ш сууц нэг ээлжиндээ 200 хүртэлх хүн байрладаг.</li> <li>- 1посттой ба өдөр шөнийн ээлжээр ажиллах 2 хамгаалалтын ажилтан байна. Росторын хугацаа 15/15 хоног. Кэмп ажиллаж байгаа тохиолдолд ажилтнуудын хоолыг кэмпээс хариуцна.</li> </ul> <p><b>Багц №В Налайх салбар:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <u>Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын бүс</u> - Хашаалсан талбайн хэмжээ 9.1га.</li> <li>- Ээлж солихоос бусад тохиолдолд өдөр тутмын харуул хамгаалалтын ажил үйлчилгээнд автомашин ашиглахгүй байж болно.</li> </ul> <p><b>Тус объектод 1 ээлжид (12 цагт):</b> Шалган нэвтрүүлэх -1, харуулын 2 посттой ба 12/12 цагийн хуваариар 2 ээлжээр ажиллана. 12 харуул хамгаалалтын алба хаагч, 1 Ахлах ажилтан үүрэг гүйцэтгэнэ. Ээлжиндээ 2-оос доошгүй галт зэвсэгтэй гарна. Ажилтнуудын хоолыг МЕРА ХХК хариуцах ба ажилтнуудын ээлж солих унааг Гүйцэтгэгч тал хариуцна.</p>

(6.2 e)	Харилцагч банкны тодорхойлолт
(13.2) болон (25.1)	Бэлтгэж ирүүлэх тендерийн хуулбар хувь нь: <b>шаардлагагүй</b>
(16.1)	<ul style="list-style-type: none"> <li>Тендерийн хэл: Монгол хэл</li> </ul>
(17.1)	<ul style="list-style-type: none"> <li>Тендерт оролцогч нь харуул хамгаалалтын үйлчилгээнд холбогдох тусгай зөвшөөрөл, гэрчилгээ ирүүлэхээс гадна дараах бичиг баримтыг ирүүлнэ: - Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх хуваарь. - Тендерт шалгарч гэрээ байгуулсан тохиолдолд тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод нийцсэн үйлчилгээг үзүүлэх, гэрээний үүргээ биелүүлэх тухай албан бичиг ирүүлнэ.</li> </ul>
(20.1)	<ul style="list-style-type: none"> <li>Тендерийн үнэ нь 1 жилийн хугацаанд үзүүлэх нийт үйлчилгээний үнэ байх ба санал болгож буй албан тушаалын ангилал тус бүрд нэг хүн нэг сарын нэгж үнийн задаргааг хамт ирүүлнэ. Нэгж үнэ гэдэг нь нэг хүнд нэг сард ногдох зардлыг хэлнэ. Энэ үнэд харуулын дарга, ажилтны зардал, түлш шатахуун, байр хоолны болон бусад зардлыг шингээн тооцож ирүүлнэ. /Орон нутагт ажиллах харуул хамгаалалтын ажилтнуудын тээврийн зардал, эргүүл хамгаалалтын автомашинуудын бензин түлш, байр хоолны зардлыг үйлчилгээ үзүүлэгч өөрөө хариуцахаар тооцон гаргана.</li> </ul>
(18.1)	<ul style="list-style-type: none"> <li>Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.</li> </ul>
(21.1)	<ul style="list-style-type: none"> <li>Төлбөрийн валют нь <b>төгрөг</b> байна.</li> </ul>
(24)	<ul style="list-style-type: none"> <li>Тендерийн баталгаа шаардахгүй</li> </ul>
(26.1)	<u>Tender@mera.mn</u> цахим хаягаар <b>НЭГ PDF</b> файлаар ирүүлнэ.
(27.1)	<ul style="list-style-type: none"> <li>2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 10 цаг 00 минут</li> </ul>
(42.2)	<ul style="list-style-type: none"> <li>Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах хоног: Ажлын 10 хоногийн дотор.</li> </ul>



**БҮЛЭГ IV. ТЕНДЕРИЙН МАЯГТ, ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ  
МЭДЭГДЭЛ БОЛОН ГЭРЭЭНИЙ МАЯГТ  
Үйлчилгээ үзүүлэгчийн тендер**

**Тендер шалгаруулалтын маягтыг бөглөх санамж**

Тендерт оролцогч нь энэхүү тендерийн маягтыг бөглөж тендерийн хамт ирүүлнэ. Хэрэв тендерийн үнэ нь хэд хэдэн валютаар илэрхийлэгдэж байгаа бол энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг нэмж ирүүлнэ.

*MEPA ХХК-ийн Худалдан авах ажиллагааны хэлтэст*

1. Бид, **[тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]**-ыг **[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.

Гэрээний төлбөрийг дараах валютаар авна. Үүнд:

№	Валютын нэр	Тус валютаар төлөх хувь	Гадаад валютын ханш /гадаад валютын нэгж хэдэн төгрөгтэй тэнцэх/	Шаардагдах гадаад валютын дүн
(а)				
(б)				

Шаардагдах урьдчилгаа төлбөр:

	Валютын нэр	Валютын дүн
(а)		
(б)		

2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс **[моо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга: \_\_\_\_\_

Албан тушаал, нэр: \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_

## ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ

### Чадварын мэдээллийг бөглөх санамж

Гэрээг хэрэгжүүлэх чадвартайгаа нотлох, эсхүл урьдчилсан сонголтод ирүүлсэн мэдээлэлд орсон өөрчлөлтийг тодотгох зорилгоор ТООЗ-ны 6 дугаар зүйлд заасны дагуу тендерт оролцогч дараах мэдээллийг бөглөж ирүүлнэ. Эдгээр мэдээлэл гэрээний хэсэг болохгүй. Шаардлагатай бол нэмэлт хуудас хэрэглэнэ. Хавсаргасан бичиг баримт нь тендерийг бэлдсэн хэлнээс өөр хэл дээр бол түүнийг орчуулсан байх шаардлагатай. Тендерт оролцогч урьдчилсан сонголтод оролцсон бол зөвхөн өөрчлөгдсөн мэдээллээ бөглөж ирүүлнэ.

**1. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр**

1.1. Тендерт оролцогч хуулийн этгээд болох талаар баталгаа болон тусгай зөвшөөрөл: **[хуулбарыг хавсаргах]**

Бүртгүүлсэн газар: **[бөглөх]**

Бизнесийн үйл ажиллагааны үндсэн хаяг: **[бөглөх]**

Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл: **[хавсаргах]**

1.2. Сүүлийн **[тоо]** жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнг жил, жилээр жагсаах: **[бөглөх]**

1.3. Ерөнхий гүйцэтгэгчээр сүүлийн **[тоо]** жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн төрөл болон хэмжээгээр ижил төстэй ажил ба гэрээний үнийн дүнг дээрх 1.2-т заасан валютаар илэрхийлж доорх хүснэгтэд бичнэ. Түүнчлэн хийхээр төлөвлөсөн болон одоо хийж буй ажил, тэдгээрийг дуусгахаар төлөвлөж буй хугацааг жагсаах.

Төслийн нэр ба улс	Захиалагч, үйлчлүүлэгчийн нэр, холбоо барих ажилтан	Гүйцэтгэсэн ажлын төрөл, дууссан он	Гэрээний үнэ
(a)			
(б)			

1.4. Гэрээг гүйцэтгэхэд санал болгож буй барилгын үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрлийн талаарх мэдээллийг доорх хүснэгтээр ирүүлнэ. Мөн ТООЗ-ны 5.2(е)-г анхаар.

Тоног төхөөрөмжийн нэр төрөл	Тодорхойлолт, хаана үйлдвэрлэсэн, ашиглагдсан хугацаа (жилээр)	Ашиглалтын байдал (шинэ, сайн, хуучин), ба тоо ширхэг	Өөрийн, түрээслэх, эсхүл худалдаж авах (хаанаас?)
(a)			
(б)			

1.5. Гэрээнд санал болгож буй удирдах болон техникийн голлох мэргэжилтний чадвар, туршлага. Намтрыг хавсаргана. Мөн ТООЗ-ны 5.3(г) болон гэрээний ерөнхий нөхцөлийн 9.1-ийг анхаар.

Албан тушаал	Нэр	Ажилласан жил (нийт)	Санал болгож буй албан тушаалтай ижил албан тушаалд ажилласан жил
(а)			
(б)			

1.6. Санал болгож буй туслан гүйцэтгэгч. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг анхаар.

Ямар ажил гүйцэтгэх	Туслан гүйцэтгэх гэрээний үнэ	Туслан гүйцэтгэгч (нэр, хаяг)	Ижил төстэй ажлын туршлага	Шийдэгдсэн байдал
(а)				
(б)				

1.7. Санхүүгийн чадавхыг харуулах аудитаар баталгаажуулсан сүүлийн [моо] жилийн санхүүгийн тайлан, ашиг орлого, алдагдлын болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн тайлан, дүгнэлтийн хамт. Дор жагсааж хувийг хавсаргана.

1.8. Чадварын шаардлагыг хангахад шаардагдаж болох санхүүгийн эх үүсвэрийн нотолгоо: бэлэн мөнгө, зээл гэх мэт. Дор жагсааж үндсэн бичиг баримтын хувийг хавсаргана.

1.9. Тендерт оролцогчийн харилцагч банкны нэр, хаяг болон утас, факсын дугаар.

1.10. Тендерт оролцогчийн одоогийн ба сүүлийн [тоо] жилийн хугацаанд оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талууд ба нэхэмжлэлийн мөнгөн дүн, шийдэгдсэн байдал.

Нөгөө тал(ууд)	Маргааны шалтгаан	Нэхэмжлэлийн мөнгөн дүн	Шийдэгдсэн байдал
(а)			
(б)			

1.11. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 4.2-т хамрагдахгүй бөгөөд эрх бүхий тухай мэдэгдэл.

1.12. Санал болгож буй ажлын хөтөлбөр (ажлын арга барил ба хуваарь). Тендерийн баримт бичгийн шаардлагыг хангахуйц тодорхойлолт, зураг болон бүдүүвч шаардлагатай бол.

**ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ**  
(Захиалагчийн албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичнэ)

*Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг бичих санамж*

*Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь хэлцэл хийгдсэн гэж үзэх үндэслэл болно. Захиалагч энэхүү гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг зөвхөн шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.*

[огноо]

[Гүйцэтгэгчийн нэр]-ийн дарга \_\_\_\_\_ Танаа,

Гэрээ байгуулах эрх олгох тухай

**[Гэрээний тусгай нөхцөлд заасан тендер шалгаруулалт/ гэрээний нэр ба дугаар]-ыг [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] гүйцэтгэхээр [огноо]-нд ирүүлсэн танай тендерийг тендерт оролцогчдод өгөх зааварчилгаанд тусгасны дагуу залруулга, тохируулга хийсэн байдлаар манай байгууллага хүлээн зөвшөөрснийг мэдэгдье.**

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш **[моо]** хоногийн дотор гэрээний маягтад гарын үсэг зурж ирүүлнэ үү.

Шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг энэхүү мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

Гэрээний маягт, нөхцөлүүдийг хавсаргав.

Захиалагч байгууллагын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## БҮЛЭГ V. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу МЕРА ХХК-ийн үйлдвэр, агуулахын объектуудыг галт зэвсэг эзэмших эрх бүхий гэрээт харуул хамгаалалтын алба хамгаалах шаардлагатай.

Хамгаалалтын бие бүрэлдэхүүнийг эрх зүйн чадамжтай, 20-45 насны, эрүүл мэнд, бие бялдрын хувьд шаардлага хангасан, хамгаалалтын ажил үүрэг гүйцэтгэх болон бие хамгаалах, тусгай хэрэгсэл эзэмших чадвартай, хариуцлагатай, зөв хандлагатай, үнэнч, шударга, цэвэрч нямбай, өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх чадвартай ажилтнуудаар бүрдүүлсэн байх шаардлагатай.

1. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт, нэмэлт, тодотгол оруулж болох бөгөөд оруулах өөрчлөлт, нэмэлтийн талаар 2 тал харилцан тохиролцож шийдвэрлэн бичгээр үйлдэнэ.
2. Харуул хамгаалалтын албаны сар тутмын ажлын гүйцэтгэлийг энэхүү гэрээний хавсралт болох "Гүйцэтгэлийн үзүүлэлт" –ийн хүснэгтээр дүгнэх ба тухайн хамгаалалтын албаны

- ажлын үр дүнг компанийн Харуул хамгаалалт, аюулгүй байдлын менежер баталгаажуулна.
3. Объектуудын хамгаалалтыг тус хамгаалалтын алба өдөр тутам удирдан зохион байгуулах ба Үйлчлүүлэгч талтай хамгаалалтын талаар нягт хамтран ажиллана.
  4. Хамгаалагч тал объектын онцлог, хууль дүрмээр тавигдах шаардлагад нийцүүлэн “Үйлдвэр, агуулахын хамгаалалтыг зохион байгуулах журам” болон “Харуул хамгаалалтын ажилтны хамгаалж буй объектод дагаж мөрдөх заавар”-ыг боловсруулан үйлчлүүлэгч талын саналыг тусган баталж мөрдөн ажиллана.
  5. Хамгаалалтын алба нь объектын хамгаалалтад ажиллах хамгаалалтын ажилтан нарыг Гэрээт харуул хамгаалалтын тухай Монгол улсын хуулийн хүрээнд сургалтад хамруулж, үнэмлэхжүүлж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч объектын харуул хамгаалалтад ажиллуулна.
  6. Хамгаалалтад ажиллах ажилтнуудын талаарх шаардлагатай мэдээллийг үйлчлүүлэгч талын хүсэлтээр Хамгаалалтын алба тухай бүр гаргаж өгч байна..
  7. Хоёр тал хамгаалж буй объектын хамгаалалтын бүс, биечлэн хамгаалах шаардлагатай хэсэг, харуулын харах секторын хүрээ, хяналтын бусад системийг ашиглах боломж зэргийг нарийвчлан судалсны үндсэн дээр хамгаалалтыг зохион байгуулна.
  8. Хамгаалалтын алба хаагчийн үүрэг гүйцэтгэх хугацаа 12 цагаас хэтрэхгүй байх ба хүндэтгэх шалтгаан гарсан тохиолдолд заавал үйлчлүүлэгч талд мэдэгдэж байна. .
  9. Байгалийн гамшиг, гэнэтийн халдлага, болзошгүй осол аваарийн үед объектын харуул хамгаалалтыг чангатгах, аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, үйлчлүүлэгч талын саналыг авч шаардлагатай үед мөрдөж ажиллана.

## **АМЖИЛТ ХҮСЬЕ!**